

Нүүдлийн соёл ба шударга худалдаа: “Тогтвортой ноолуур” дахь ёс зүйн асуудал

Эрик Трифт
Виннипегийн их сургууль

Сүүлийн жилүүдэд *шударга худалдааны* хөдөлгөөн (англиар *fair trade*) худалдан авагчдын дунд олон улсын зах зээл дэх шударга бус харилцааг шүүмжилсэн ойлголтыг бий болгоход хувь нэмэр оруулсан нь гарцаагүй (1). “Шударга худалдаа” нь олон улсын зах зээлд ил тод, шударга, тэгш байдлыг дэмжсэн хөдөлгөөн бөгөөд голдуу хөгжиж буй орнуудаас кофе, жимс, хөвөн даавуу гэх мэт бүтээгдэхүүнийг худалдан авахад нийгэм, эдийн засаг, байгаль орчны шударга, ээлтэй нөхцөл байдлын шаардлагыг хангасан жижиг үйлдвэрлэгч, фермерийн хоршоо зэрэг ханган нийлүүлэгчдэд гэрчилгээ олгон, зах зээлийн суурь үнэ дээр тодорхой хувийн урамшуулал олгох бөгөөд авсан бүтээгдэхүүнээ тусгай барааны тэмдэг ашиглан өндөр үнээр хэрэглэгчдэд худалдана. Энэхүү тогтолцоо нь энгийн худалдааны сүлжээнээс илүү шударга, ёс зүйтэй нийцсэн хэлбэр байх зорилготой юм (2–4).

Гэтэл шударга худалдааны сүлжээнд хамрагдсан зарим жижиг үйлдвэрлэгчдийн дунд явуулсан антропологиин судалгаанаас үзэхэд олон улсын байгууллага, ханган нийлүүлэгч хоёрын хооронд ёс зүйн үзэл, хандлагын зөрчил гараад байгаа нь судлах ёстой асуудал болж байна (5–8). Шударга худалдааны баталгаат гэрчилгээ олгоход нарийн тодорхой, хэмжээст, түгээмэл үзүүлэлтээр нийгмийн шударга ёсны байдлыг хэмжихийг зорьдог тул онолын үүднээс *деонтологийн ёс зүй* буюу ерөнхий үүрэг, дэг ёсоор зөв бурууг ялгаж үздэг ёс зүйн зарчимд суурилсан гэж үзэж болно. Тухайлбал, аль ч оронд зах зээлийн шударга үнэ ханш, хүүхдийн эрх, эмэгтэйчүүдийн эрхийн асуудал зэргийг ижил зарчимаар тодорхойлж үнэлнэ. Иймэрхүү хандлагын давуу тал нь ойлгомжтой, тодорхой дүрэм стандарт боловсруулан хэрэгжүүлэх, мөн түгээмэл эрх үүрэг, тэгш байдлыг дэмжихэд оршино. Гэтэл нөгөө талаас аливаа соёл иргэншил өөрийн гэсэн үнэлэмж, ёс заншилтай байдаг тул зөвхөн ёс зүйн нийтийн зарчмаар хандсанаар тухайн соёлын үнэт зүйлсийг гадуурхан үгүйсгэсэн байдал үүсэх магадлалтай гэж дээр дурдсан судлаачид анхааруулсан байна.

Монголын ноолуурын үйлдвэрлэлийн талаарх судалгааныхаа хүрээнд бид малчдын ёс зүй, байгаль орчны асуудлыг “нүүдлийн соёл иргэншлийн” үүднээс хэрхэн тодорхойлдогийг харуулахыг зорьсон. Бидний малчидтай хийсэн ярилцлагаас харахад тэд нэг талаас буян, халамж, элбэг баян байх, өгөөмөр зан зэрэг үнэт зүйлсийг эрхэмлэдэг *ариун журмын ёс зүйн* зэрэгцээ деонтологийн ёс зүйн тодорхой хэлбэр болох монгол цээрлэх ёсыг (9) эрхэмлэн зөв, бурууг ялгаж тайлбарлана. Энэ үүднээс бид монгол малчдын “сайн хүн”, “буянтай хүн”, “ёс мэддэг хүн” зэрэг ёс зүйн ойлголтыг шударга худалдааны аливаа сүлжээний хүрээнд хэрхэн тусгаж болохыг авч үзсэн. Тухайлбал, эцсийн хэрэглэгчдийн ёс зүйн ойлголтыг бусдад тулгалгүйгээр, “шударга” хэмээн нийтлэг ойлголт бий болгон шударга худалдааны зах зээлийн аргаар бусдын соёлыг хүндлэн, харилцан ойлголцох нөхцөл бүрдүүлэх боломжийг судлах шаардлагатай.

Шударга худалдааг *ёс зүйн олон ургальч* үзлээр хандаж бүтээхийн тулд ёс зүйн нарийн төвөгтэй асуудлаа түгээмэл зөвшилцөл бий болгож тунхаглах биш, харин субъект хоорондын яриа хэлцлийг тууштай байлгахыг шаарддаг (10,11). Иймээс энэхүү өгүүлэлдээ нүүдлийн соёл иргэншил, түүнийг хадгалж хамгаалахтай холбоотой ёс зүйн асуудлыг жишээ болгож, ёс зүйн олон ургальч хандлага агуулсан шударга худалдааны механизмыг боловсруулах зарим арга зам авч үзсэн юм. Үүнд, ноолуурын зах зээл дэх ёс зүйн хоёр боломжит загварыг авч үзэхдээ: (1) ЮНЕСКО-гийн Дэлхийн өв ба биет бус соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааны хүрээнд ашигладаг “*бүх нийтийн шилдэг үнэ цэнэ*” (англиар *Outstanding Universal Value*) гэсэн ойлголттой нийцсэн *соёлын эрх* дээр суурилсан шударга худалдааны деонтологийн ёс зүйн тогтолцоо, (2) өртөгийн гинжин хэлхээн дэх оролцогчдын *харьцуулшгүй* үнэт зүйлсийн хоорондын зөрчлийг илчлэх, тохиролцоход чиглэгдсэн *мета ёс зүйн* хэлэлцүүлгийг шударга худалдааны сүлжээнд суурилсан тогтолцоо байна. Соёлын эрхэд суурилсан хандлага нь хэрэглэгчид болон барааны сүлжээний бусад оролцогчдыг идэвхжүүлэхэд илүү үр дүнтэй бөгөөд одоо байгаа шударга худалдааны сүлжээний тогтолцоотой сайн нийцэх боловч эрх мэдлийн ялгаа, ёс зүйн олон ургальч үзлийг агуулах боломж хязгаарлагдмал байдаг. Үүнийг эсрэгээр, шударга худалдааны талаарх хэлэлцээрийн хандлага нь тодорхой зааварчилга өгөхгүй ч соёл-угсаатны зүйн судалгааны үндэслэлтэй арга барилыг нээх боломжийг олгодог бөгөөд энэ нь хэрэглэгчдэд соёл хоорондын ёс зүйн талаар утга учиртай ойлголт өгөх боломжтой.

“Тогтвортой ноолуур”-ын стандарт ба соёл уламжлал

Энэхүү өгүүлэл нь ЮНЕСКО-гийн ивээл дор Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнтэй хамтран Монголын ноолуурын зах зээлийн сүлжээн дэх ёс зүй, тогтвортой хөгжлийн асуудалд анхаарлаа хандуулсан судалгаанд зарим тайлбар, дүгнэлт өгсөн юм. Тус багийн судалгаанд 2022 онд Архангай, Баянхонгор, Өмнөговь

аймгуудад малчин, ченжүүдийн дунд хийсэн 70 удаагийн ярилцлагаас сэдэв аваад, өмнөх судалгаандаа (12) тулгуурлан малчины соёлын үнэт зүйлсийг тогтвортой ноолуурын стандартын зарим заалттай харьцуулж үзээд, шударга худалдаа болон “тогтвортой” буюу хүн, нийгэм, байгаль орчиндоо ээлтэй бүтээгдэхүүнийг тодорхойлсон стандартад соёлын үнэ цэнийг тусгах зарим бодит хувилбаруудыг санал болгож байна.

Ноолуур бол үнийн дүнгээр Монгол улсаас гаргаж буй нийт түүхий эдийн экспортын 3.6 хувийг нь бүрдүүлдэг бөгөөд сэргээгдэх нөөцөд суурилсан цорын ганц томоохон экспортын бүтээгдэхүүн юм (13). Гэвч сүүлийн жилүүдэд олон улсын, олон нийтийн болон эрдэм шинжилгээний хэвлэл мэдээлэлд монгол ноолуурын үйлдвэрлэлийг байгаль орчинд тун халтай аж ахуй гэж тодорхойлоход ямааг бэлчээрийн доройтол, зэрлэг ан амьтдын хомсдол, цөлжилтөд хүргэсэн гэж мэдээлсэн байна (14–18). Нийгэм, байгаль орчны сөрөг нөлөөллөөс болж дэлхийн хувцасны үйлдвэрлэлийн салбар улам бүр ээдрээтэй болж байгааг анхаарч, энэ үед хэрэглэгчид, брэндүүдийг монгол ноолуураас зайлсхийхийг уриалж байна. Тус салбар нь хог хаягдал, микропластик бохирдлын гол эх үүсвэр гэж тодорхойлсон бөгөөд дэлхийн нүүрсхүчлийн хийн ялгаруулалтын 10 орчим хувийг үүсгэдэг, мөн дэлхийн түвшинд усны хоёр дахь том хэрэглэгч салбар юм (19). Мөн түүнчлэн хувцасны үйлдвэрлэлийн салбар нь хөдөлмөрийн мөлжлөг болон ажлын байрны аюултай нөхцөл байдалтай холбоотой байсан нь НҮБ-ын Тогтвортой загварын холбооноос хүлээн зөвшөөрөгдсөн санаачилгад ажлын байрны аюулгүй байдлын арга хэмжээг оруулахад хүргэсэн (20).

Ноолуурын салбарт эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд янз бүрийн стандартыг нэвтрүүлсэн бөгөөд Монгол, Өвөрмонголд ноолуурын гурваас багагүй төрлийн стандартыг санаачилан боловсруулан хэрэгжүүлж байна. Үүнд, худалдааны тусламжийн сангаас (ABTF) Өвөрмонголд нэвтрүүлсэн “Сайн ноолуур” стандарт, Тогтвортой ноос ноолуурын эвсэлийн (SFA) Монголд удирддаг “Тогтвортой ноолуурын” стандарт болон Монгол Улсын Баянхонгор, Архангай, Хэнтий аймгуудад Тогтвортой ноолуурын холбоогоор дамжуулан үйл ажиллагаа явуулдаг Agronomes et Vétérinaires Frontières (AVSF) байгууллагаас олгодог “Тогтвортой ноолуур” гэрчилгээ болно (21–23). Эдгээр гурван арга хэмжээ нь шударга худалдаа, эсвэл органик бүтээгдэхүүнд баталгаа олгодог зарчимтай адилаар малчидыг олон улсын гэрчилгээ олгогч байгууллагын заасан шалгуур биелүүлж, бүртгэлийн бичиг болон аудитаар өөрсдийгөө шалгуулах хэлбэрээр удирдана.

Тогтвортой ноолуурт гэрчилгээ олгох эдгээр санаачилга нь Монголын бэлчээрийн мал аж ахуй дахь тогтвортой хөгжлийн асуудалд бусдын анхаарал хийгээд санхүүгийн дэмжлэгийг үр дүнтэй татаж байгаа ч малчид, эцсийн хэрэглэгчид болон стандартын байгууллагын ашиг сонирхолыг тэгш дэмжээгүй. Олон малчдын хувьд соёл уламжлал, ёс заншилаа хадгалж хамгаалах нь чухал гэж бидэнд тайлбарласан

бөгөөд бэлчээрийн мал аж ахуй, нүүдэллэх ёс, түүнтэй холбоотой зан үйл, уламжлалт мэдлэг ухаан нь хөдөө нутагт монголоороо аж төрж, улс үндэснийхээ өв соёлыг тээж, сайн сайхан, бүрэн эрхт байдлаар хангагдсан амьдрах боломжийг бүрдүүлж байгаа юм. Гэсэн хэдий ч тогтвортой ноолуурын стандартууд нь соёлын хүчин зүйлд хамгийн бага анхаарал хандуулдаг бөгөөд үүний оронд ихэнх тохиолдолд мал аж ахуйн тогтсон дадлыг зориудаар өөрчилдөг техникийн "сайжруулалт"-ыг онцолдог. Жишээлбэл, АВТФ-ийн Сайн ноолуурын стандартад ямаагаа самнахад зөөлөн материалтай олсоор уяж тогтоосон, ямар нэгэн гаднах байгууламжид уялгүйгээр, босоо байрлалд, мөн гар самаар биш болж өгвөл цахилгаан хайчаар хяргах арга ашиглах шаардлага тавьсан (шалгуур 4.3). Тодруулбал эдгээр нь ямаа самнах, хонь хяргах уламжлалт гар аргаас тэс ялгаатай юм. Энэхүү стандартад соёлын хүчин зүйлсийг ганцхан хүүхдийн хөдөлмөрийг хязгаарлах тухай хэсэгт дурдахдаа 12 нас хүрээгүй хүүхдийг хөдөлмөр эрхлэхийг хориглосон бөгөөд зөвхөн "тухайн айл эсвэл ард нутгийн соёл уламжлалыг дамжуулах зорилго бүхий" даалгавар олгохыг зөвшөөрнө (6.1-р шалгуур).

Хөдөлмөр, уламжлалт соёл хоёр давхцах байдлыг хүлээн зөвшөөрсөн энэхүү заалт нь үндсэндээ ОУХБ-н 138 болон 182-р тунхаглалд (24,25) заасны дагуу хүүхдийг аюултай болон мөлжлөгийн ажлаас хамгаалах зорилготой. Гэвч "соёл", "хөдөлмөр-эдийн засаг" хоёрыг тусгай хүрээ гэж ийнхүү ангилж үзэхээр цаагуураа соёлын ач холбогдол бүхий ажлын эдийн засгийн ач холбогдол давамгайлаагүй байх ёстой, өөрөөр хэлбэл эдийн засгийн хэт ашигтай байдал бол тухайн уламжлалт ажлыг зөвхөн "соёл уламжлалыг дамжуулах зорилго бүхий" ажил болохгүй гэсэн ойлголт агуулсан. Түүнчилэн энэ стандартаар зөв зохистой хөдөлмөр ямар байх тухай өгүүлэхдээ ёс зүйн хэд хэдэн үзэл бодол агуулдаг: нэгдүгээрт, өрхийн эдийн засгийн хүрээнд "ажил" болон "хөдөлмөрийн бус" үйл ажиллагааны хооронд хатуу заагийг тогтоох нь зүйтэй, хоёрдугаарт, хүүхдэд албан боловсрол олгох нь өрхийн аж ахуйд оролцуулах замаар уламжлалт мэдлэг боловсрол олгох аргаас илүү, гуравдугаарт, 13 нас хүрээгүй бага насны хүүхдүүдийг ихэнх төрлийн ажил хөдөлмөрөөс тусгаарлах нь зөв. Энэ мэтээр нийгмийн нэгдлийг ажил, гэр бүл, сургууль зэрэг өөр өөр бүтэцтэй тайлбар болгон хуваахыг зөвтгөх, улмаар "гэр" эсвэл "ажлын" орчин дахь албан бус боловсролын зүй тогтолыг алдагдуулж байна. Гэтэл уг хүрээнд уламжлалт соёл, мэдлэгийг тогтвортой хадгалж, хойч үедээ өвлүүлэх нь олон орны нүүдэлчин ард түмний соёлын дархлааны суурь хэсэг мөн гэж судлаачид үзжээ (26–28). Мөн дөрөвдүгээрт, стандартын эдгээр заалтаараа хүүхэд, мал амьтны эрхийг хамгаалахын тулд аливаа сөрөг нөхцөл зүйлээс урьдчилан сэргийлэх ёстой гэсэн зарчим агуулсан бөгөөд нөгөөтэйгүүр амьжиргааны түвшин эсвэл тогтвортой хөгжлийг хэмжих үзүүлэлтүүдэд нутгийн уугуул иргэдийн соёлын хандлагыг тусгах санаачилгаас жишээ авч, соёлын таатай нөхцөл бүрдүүлэх аргаар хүн, мал амьтан, байгаль орчны эерэг харилцаа үүсгэн хамгаалах арга нь соёл уламжлалд илүү ээлтэй, үр дүнтэй байх (29,30) юм.

Дээрх жишээнээс харахад ёс зүйтэй, тогтвортой ноолуурын үйлдвэрлэлийг бий болгоход чиглэсэн стандартууд нь ёс зүйн бусад чиг хандлагатай зөрчилдөж болзошгүй. Норматив ёс зүйн онол, тухайлбал зөв, бурууг ялгахад чиглэсэн арга барилууд нь үнэн хэрэгтээ нэлээд олон янз бөгөөд үүнд: тухайн нөхцөл байдалд эерэг үр дүнг нэмэгдүүлэх сонголтыг шаарддаг хандлага болох *үр дагаврыг багтаасан ёс зүй*; үнэнч, өгөөмөр сэтгэл зэрэг ёс суртахууны сайн зуршлыг шаарддаг хандлага болох *ариун журмын ёс зүй*; мөн зөв, зохисгүй үйлдлийг ангилсан үл эвдэх дүрмийг дагаж мөрдөхийг шаарддаг хандлага болох *деонтологи* буюу *үүрэгт суурилсан ёс зүй* байна.

НҮҮДЛИЙН СОЁЛ, ШУДАРГА ХУДАЛДААНЫ ХАНДЛАГА

Шударга худалдааны стандартууд нь дэлхийн хаана ч, ямар ч нөхцөл байдалд хамаарах худалдааны дүрмийг тодорхойлсон деонтологийн арга барилтай нягт уялдаатай байдаг. Дээр дурдсан гурван стандартын дагуу байгалийн баялгийг зүй бусаар ашиглах, хүүхдийг албадан хөдөлмөр хийлгэх, амьтныг гэмтээх нь ямагт буруу байдаг бөгөөд эдгээр ёс зүйн дүрэм газар сайгүй адилхан үйлчлэх ёстой. Харин амьтдын эрх, хүний эрх зэргийг нийтлэг бөгөөд халдашгүй зарчим гэж үзвэл уламжлалт соёлоо хамгаалах зорилгыг “зайлшгүй” гэхээсээ илүү “хүсүүштэй” зүйл хэмээн түүнээс давж гарах хандлагатай. Сүүлийн үед олон улсын хөгжлийн салбарт хүний эрхэд суурилсан хандлага нь газар авсан бөгөөд энэ нь төртэй харилцах, ардчилсан хариуцлагыг шаардах, хөгжлийн бодлогыг улс төрийн хүрээнд авч үзэж хэлэлцэх зорилгуудыг дэмжинэ (31,32). Хүний эрхэд суурилсан олон улсын хөгжлийн зарим санаачилгатай ажлаас санаа авч, одоо байгаа ноолуурын стандартад соёл, хангалуун амьжиргаа, нүүдэлчин малчдын бүрэн эрхт байдалд харьцангуй бага ач холбогдол өгдөгийг анхааран, шударга худалдаанд *соёлын эрхийн* тухай ойлголтыг тусгах нь зүйтэй гэж бид санал болгож байна.

Үндсэн ойлголтыг авч үзвэл, соёлын эрхийг уугуул иргэдийн эрхийн тухай хоёр үндсэн баримт бичиг болох ОУХБ-ын 169 дүгээр тунхаглал болон Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ын тунхаглал (UNDRIP) зэрэгт тусгаж өгсөн байдаг бөгөөд эдгээр нь төрөөс уугуул иргэдийн уламжлалт зан үйл, газар ашиглалтыг хамгаалах, уугуул иргэдэд нөлөөлж болох дэд бүтэц, хөгжлийн төсөл батлан хэрэгжүүлэхээс өмнө нутгийн зөвлөлөөс зөвшөөрөл авах үүргийг заах, мөн нутгийн өөрийгөө захирах эрх хүлээн зөвшөөрөхийг шаардсан байна (33,34). Тухайлбал, ОУХБ-ын 169-р тунхаглалд “нийгэм, соёл, шашин, оюун санааны үнэт зүйлс, зан үйлийг” хүндлэн хамгаалах, “үнэт зүйл, зан үйл, нийгмийн тогтолцооны бүрэн бүтэн байдлыг” хүндэтгэх (5-р зүйл), мөн зөвлөлдөх эрх болон “эдийн засаг, нийгэм, соёлын хөгжил” зэрэг асуудлаар өөрийгөө удирдах эрхийг хүлээн зөвшөөрөхийг шаардсан (7 дугаар зүйл). ОУХБ-ын 169-р тунхаглал нь мөн дэд бүтэц, хөгжлийн төсөл хэрэгжүүлэхийн өмнө “нийгэм, оюун санааны, соёл, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн” судалгааг

хийхийг шаардсан (7-р зүйл) бөгөөд уламжлалт үйл ажиллагаа нь “соёлыг хадгалж хамгаалах, эдийн засгийн бие даасан байдал, хөгжилд чухал хүчин зүйл болдог” гэж тунхаглажээ (23 дугаар зүйл).

Энэхүү эрх, үүргийн багц нь эдгээр хоёр баримт бичигт цөөнхийн уугуул иргэдтэй холбоотой төрийн өмнө хүлээсэн үүрэг гэж томъёолсон ч шударга худалдааны сүлжээг соёлын эрхийн үүднээс үнэлэхэд ашигтай суурь тогтолцоо болж өгдөг. Тухайлбал, шударга худалдааны ноолуурын баталгаа, гэрчилгээ олгохдоо *соёлын эрхийг* дэмжинэ гэхэд ноолуур ханган нийлүүлэгчдийг бэлчээрийн уламжлалт нүүдлийн мал аж ахуй эрхэлсэн, өрх айлын түвшинд таван хошуу мал малласан малчид мөн гэж нотлох арга байж болно. Энэ нь ноолуурын нэмүү өртгийн гинжин хэлхээнд оролцогчид ямааны эрчимжсэн, суурин аж ахуйн хэлбэрийг дэмжихгүй байдаг бөгөөд Монголын нүүдлийн мал аж ахуй, нүүдлийн соёлыг хамгаалахын илрэл болно. Өвөр Монголын туршлагаас харахад ямааны мал аж ахуйг эрчимжүүлэх тусмаа бүтээгдэхүүний үнэ өртөг хямд, чанар жигд сайн боловч нүүдлийн соёл, түүнтэй холбоотой үнэт зүйлс алдагдах байдал ажиглагдана (35). Иймээс Монголын ноолуур нь үнэ ханш, бодит чанараараа БНХАУ-д үйлдвэрлэсэн ноолууртай өрсөлдөх бэрхшээлтэй ч “нүүдлийн соёлд ээлтэй” хэмээн өрсөлдөх боломжтой хэмээгээд, шударга худалдааны түгээмэл дадал туршлагын дагуу зах зээлийн үнэ ханш дээр нэмэгдэл тооцох, урамшуулал олгох аргыг ашиглан (36) соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч малчин, нүүдлийн соёлын өвийг дэмжих байгууллагуудад тэтгэмж урамшуулал олгох аргаар монголын нүүдлийн мал аж ахуй, нүүдлийн соёлыг тэтгэх боломжтой.

Нэмж өгүүлэхэд, Монголын олон газар нутгийн малчид уурхайн компани зэрэг томоохон газар ашиглагчидтай харилцахдаа улс төрийн хүчин чадал сул дорой, төлөөлөл дутмаг байдгаасаа болж бухимдаж байна (37–39). Ийм нөхцөлд шударга худалдааны сүлжээ нь ОУХБ-ын 169-р тунхаглал, НҮБ-ын Уугуул иргэдийн эрхийн тухай тунхаглалд заасны дагуу орон нутагт дэд бүтэц, хөгжлийн төслүүдэд зохих зөвлөлдөх, орон нутгийн оролцоог шаардан нэмүүлэх улс төрийн нөлөөллийн механизм болж ажиллах боломжтой.

Деонтологийн ёс зүйн хүрээнд нүүдлийн соёлын өвийг дэмжих өөр нэг загвар бол ЮНЕСКО-гоос Дэлхийн өвийн дурсгалт газруудыг тодорхойлохдоо ашигладаг “бүх нийтийн шилдэг үнэ цэнэ” (БНШҮЦ) юм. ЮНЕСКО энэ нэр томъёог “улс үндэстнийхээ хил хязгаарыг давж, нийт хүн төрөлхтний өнөөгийн болон хойч үеийнхэнд нийтлэг ач холбогдолтой” байгалийн болон соёлын онцгой чухал үнэт зүйлсийг тодорхойлоход ашигладаг (40). Деонтологийн ёс зүйн үүднээс авч үзвэл, БНШҮЦ нь соёлын чухал үнэт зүйлсийг хаана, хэнд оршихоос үл хамааран хамгаалах ёстой хэмээн ёс зүйн чухал үүрэг заадаг зарчимтай. Зарим судлаачдын үзэж байгаагаар БНШҮЦ нь колончлолын хандлагатай, учир нь нутаг нутгийн уугуул иргэдийн соёлын өвийг тэдний өмч биш, харин хүн төрөлхтний нийтийн өмч гэсэн агуулгатай

(41). Нөгөөтэйгүүр соёлын өвийг аливаа үндэстний бүтээн байгуулалтын ажилд ашиглаж ирсэн туршлага багагүй бөгөөд “онцгой чухал” ба “бүх нийтийн” соёлын өвийг эзэмшин, хадгалж хамгаалснаар тусгаар улс үндэстэн оршин тогтнохыг зөвтгөх, эсвэл биет бус соёлын өвийн хувьд үндэсний “патент”-ыг баталгаажуулах (42) зэрэг төрийн арга механизм бас бий.

Монгол улсын хувьд соёлын өвийг “нүүдлийн соёл иргэншил” гэж ихээхэн хэмжээгээр илэрхийлсэн бөгөөд засаг захиргааны бүх шатанд соёлын ач холбогдолтой дурсгалт газар, соёлын биет бус өвийг тээгч зэрэг бүртгэл жагсаалт хөдөлсөн байдаг. Онцлон тэмдэглэхэд, Монгол Улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэлд бэлчээрийн нүүдлийн мал аж ахуй оршин тогтнохтой шууд хамааралтай гуч орчим зүйл тодорхойлогдсон байдаг (43). Энэхүү жагсаалтыг “тогтвортой нүүдлийн соёлд” зайлшгүй агуулагдах шаардлагатай зүйлийн төлөөллийн жагсаалт болгож үзвэл шударга худалдааны сүлжээний хүрээнд хоёр төрлийн зохицуулалт санаачилах боломжтой. Нэгдүгээрт, тогтвортой ноолуурын стандарт олгогч байгууллагууд малчдын дунд бэлчээрийн менежментийн сургалт зэрэг байгаль орчин хамгаалах арга хэмжээ зохион байгуулж, санхүүгийн дэмжлэг үзүүлдэг мэт орон нутаг болон улсын бүртгэлд орсон соёлын өвийг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үйлсийг дэмжих шаардлага тавьж болно. Хоёрдугаарт, олон улсад ноолуур худалдах бренд компаниудад улс, орон нутгийн засаг захиргааны нэгжээр батлагдсан энэхүү соёлын өвийн жагсаалтад орсон зарим зүйлийг сурталчилах шаардлага тавьж болно. Бидний судалгаагаар ноолуурын олон улсын зар сурталчилгаанд Монголын нүүдлийн соёлын дүрслэл тун ховор бөгөөд монголын соёлыг харьцангуй өнгөцхөн байдлаар, зөвхөн онгон зэрлэг байгальтай зэрэгцүүлэн дүрсэлсэн байх жишээтэй (44,45) боловч ноолуурын зах зээлийн хүчинд оршин тогтнодог нүүдлийн соёл иргэншил, түүнийг бүрдүүлдэг язгуур урлаг, зан үйл, ахуйн соёл зэрэг өвийг хүндлэн таниулах боломж бас харагдаж болно.

Деонтологийн хандлага нь бүх нийтийн дүрэм, стандартад төвлөрдөг бол *мета ёс зүйн* хандлага нь зөв, бурууг хэрхэн ялгах онолуудыг харьцуулан судлах хандлага болно. Монголын малчидтай хийсэн ярилцлагаас харахад малчин, ноолуурын бүтгээгдэхүүний эцсийн хэрэглэгчдийн дунд ёс зүйн ерөнхий зарчмын талаар санал нэгдэж болох ч тэдгээрийг хэрхэн эрэмбэлэх талаар санал зөрөлдөөнтэй байдаг.

Ёс зүйн онолын хэлээр бид үнэт зүйлсийг нийтлэг хэмжүүрээр харьцуулах боломжгүй бол *харьцуулшгүй үнэт зүйл* (англиар *incommensurable*), тэдгээрийн хооронд сонголт хийх арга байхгүй бол *зүйрлэшгүй үнэт зүйл* (англиар *incomparable*) гэж хэлнэ (46,47). Харьцуулах боломжгүй байдлын асуудлыг ойлгохын тулд бид амьтдын эрхийн талаарх өөр өөр зарчмыг авч үзье. Бид малд хор хөнөөл учруулахгүй, зовоохгүй байх гэсэн зарчмын талаар санал нэгдэж болох ч энэ нь РЕТА байгууллага ноолуурын эсрэг компанит ажлаа зарласнаар ямаа самнах нь ёс

зүйгүй гэсэн үг үү (48)? Хоол хүнсээ төхөөрөхдөө хөгшин ямаа нядлах нь ёс зүйгүй хэрэг үү? Веган хүний үзлээр амьтны гаралтай бүтээгдэхүүн, тэр дотроо ноолуур хэрэглэх нь ёс зүйгүй гэж үү? Эсвэл Монголын зарим малчидын хэлж буйгаар хүн-малын эерэг харилцаа хамаарал бүхий бэлчээрийн мал аж ахуйгаас аж үйлдвэрийн фермийн мал үйлдвэрлэл нь ёс зүйд нийцэхгүй байна уу?

Тэгвэл зүйрлэшгүй үнэт зүйлсийн хувьд бид хоорондоо ялгаатай зарим туршлагыг авч үзье. Жишээ нь веган байх, малчин байх хоёр нь эсрэг тэсрэг, аль нэгийг нь сонгох нийтлэг үндэслэл байхгүй. Мөн түүнтэй адил тодорхой газар нутагт байгаль орчныг хамгаалах, эдийн засгийг хөгжүүлэх зэрэг асуудал бас байна. Байгаль орчны тогтвортой байдлыг эрхэмлэдэг этгээд, дизайнер Стелла Маккартнитэй адил шинэ ноолуур ашиглахаас бүрмөсөн зайлсхийх (49) бол түүний эсрэгээр тогтвортой амьжиргааг эрхэмлэдэг, ядуурлыг бууруулах хүсэлтэй этгээд нь Монгол Улсын засгийн газартай адил ноолуурын нэмүү өртөг, экспортийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийг хөгжүүлэх (50) аргыг сонгох болно. Ноолуурын үйлдвэрлэл газрын доройтолд нөлөөлсөн гэдэгтэй бид санал нийлж болох ч ноолуурын үйлдвэрлэл эрхэлдэг малчдын онцолж байгаагаар уул уурхайн олборлолт үүнээс ч дордож магадгүй юм. Эрчимтэй тариалсан органик хөвөнг ашиглан хувцасны үйлдвэрлэлд бага газар ашиглах, эсвэл *нөхөн төлжих ноос* (англиар *regenerative wool*) дэмжигчдийн санал болгосны дагуу байгалийн бэлчээрт өсгөсөн малын эслэгийг ашиглан биологийн олон янз байдлыг хадгалах нь ёс зүйн хувьд илүү дээр үү (51,52)?

Эдгээр нөхцөл байдлын ёс зүйн нарийн төвөгтэй байдлыг хүлээн зөвшөөрөх нь биднээс деонтологийн хандлагын хатуу дүрмээс цаашаа бодохыг шаарддаг. Өмнөх судлаачдын санал болгосон “ёс зүй гэж ухамсарлахуйц” хандлагыг дагаж (11), мета ёс зүйн хэлэлцээрээр өдөөгдсөн шударга худалдааны сүлжээ нь өдөр тутмын ёс зүйн шийдвэр гаргалт дахь эмх замбараагүй байдлыг хүлээн зөвшөөрч, дүрэм стандартаар далдлагдсан үзэл бодол, туршлагад анхаарлаа хандуулах юм. Ийм сүлжээ нь малчдаас эхлээд эцсийн хэрэглэгч хүртэл янз бүрийн оролцогчдын тулгарч буй ёс зүйн асуудлуудыг хүлээн зөвшөөрч, нэмүү өртгийн гинжин хэлхээний дагуу мэдээллийг ил тод хуваалцахад дэмжлэг үзүүлж чадна. Өөрөөр хэлбэл, шударга худалдааны байгууллага нь судалгаа, эрдэм шинжилгээний хурал, салбар уулзалт зэрэг хэлбэрээр мэдээлэл солилцох боломж бүрдүүлснээр тал талын этгээд ёс зүйн талаар илүү мэдээлэлтэй шийдвэр гаргах, дүн шинжилгээ хийх боломжтой болно.

ДҮГНЭЛТ

Деонтологийн соёлын эрхэд суурилсан буюу “бүх нийтийн шилдэг үнэ цэнэ”-ийн хандлага нь одоо байгаа стандарт, гэрчилгээ баталгаажуулалтын тогтолцоонд

соёлын шинэ шалгуур, үзүүлэлтүүдийг нэмэхэд харьцангуй хялбар байдаг тул өмнөх шударга худалдааны сүлжээний загвартай сайн нийцдэг. Соёлын тухай шалгууруудыг түгээмэл ба халдашгүй эрх гэж томьёолох нь эцсийн хэрэглэгчид болон нэмүү өртгийн гинжин хэлхээний бусад оролцогчдыг аливаа зөрчлийн эсрэг арга хэмжээ авахад түлхэц болно. Гэхдээ энэ арга нь эрх мэдлийн ялгаа, соёл-ёс зүйн олон ургальч үзэл, тухайлбал түрүүний жишээгээр мал амьтны эрхийн талаарх ойлголтуудыг шийдвэрлэх чадвар хязгаарлагдмал байдаг. Анхдагч бүтээгчид, эцсийн хэрэглэгчид хоёр харьцуулшгүй үнэт зүйлсийг эрхэмлэдэг нөхцөлд эцсийн худалдан авагчийн үзэл бодол нь давамгайлах эрсдэлтэй.

Үүний эсрэгээр, шударга худалдааны мета ёс зүйн хандлага нь тодорхой зааварчилга өгөхгүй ч соёл-угсаатны зүйн судалгааны үндэслэлтэй арга барилыг нээх боломжийг олгодог бөгөөд энэ нь хэрэглэгчдэд соёл хоорондын ёс зүйн талаар утга учиртай ойлголт өгөх боломжтой. Ноолуурын зах зээлийн талаарх мэдлэг мэдээлэл түгээх, хуваалцах нь тэгш бус байдал, шударга бус байдлыг, тэр дундаа хүн, байгаль орчин, нүүдлийн соёлд ээлтэй бус үйлдлийг ухаант байдлаар шүүмжлэх, хэлэлцэн шийдвэрлэхэд дөхүүлнэ. Ихэнх худалдан авагч авсан бүтээгдэхүүн бүрийн эх үүсвэрийн талаар нарийвчилсан техникийн судалгаа хийх хүсэлгүй байх нь гарцаагүй, гэхдээ бараа бүтээгдэхүүний гарал үүслийн түүхтэй сонирхож магадгүй юм. Энэ утгаараа ноолуурын баталгаат гэрчилгээнд байгаль орчны нягтлан бодох бүртгэлийн тоон мэдээлэл гэхээс илүү нэмүү өртгийн гинжин хэлхээн дэх янз бүрийн оролцогчдоос ёс зүйн тайлбар өгсөн түүх цуглуулж хуваалцах нь илүү үнэ цэнэтэй байж болох юм.

Бидний энд дэвшүүлсэн саналууд нь ноолуурын ёс зүйт, тогтвортой сүлжээг бий болгох асуудлыг шийдвэрлэх эцсийн шийдэл биш, харин ноолуурын үйлдвэрлэлийн ёс зүйд антропологийн шүүмжлэл авчрах зорилгыг тусгасан болно. “Сайн ноолуур”, “Тогтвортой ноолуур” гэх мэт гэрчилгээ, стандарт нь энгийн, гаргацтай, хэмжигдэхүйц үзүүлэлтүүдийг багтаасанаар хялбар ойлгомжтой болсон. Гэсэн хэдий ч үүнийг шүүмжлэлтэй өнцгөөс харахад ийм хэрэгсэл нь малчин, худалдагч, эцсийн хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралд тохиолддог “эмх замбараагүй” ёс зүйн асуудлыг шийдвэрлэх зай үлдээсээр байгаа нь тодорхой байна. Шударга худалдааны санал болгосон хандлага нь дүрэм журам, аудитын баталгаанаас давж, энэхүү эдийн засгийн салбар дахь оролцогчдыг татан оролцуулж, тэдний харьцуулшгүй болон зүйрлэшгүй ёс зүйн байр суурийг нухацтай авч үзэх замаар ноолуурын ёс зүйн талаар утга учиртай, соёл хоорондын ойлголтыг дэмжих боломжийг бүрдүүлнэ гэж найдаж байна.

Ашигласан материал

1. Stenn TL. The cultural and political intersection of fair trade and justice: managing a global industry [Internet]. First edition. New York, NY: Palgrave Macmillan; 2013 [cited 2024 May 22]. Available from: <http://site.ebrary.com/id/10800115>
2. Fairtrade International. What is Fairtrade? [Internet]. 2024 [cited 2024 Jul 27]. Available from: <https://www.fairtrade.net/about/what-is-fairtrade>
3. WFTO. World Fair Trade Organization. 2024 [cited 2024 Jul 27]. Discover The Power Of Fair Trade Enterprises With WFTO. Available from: <https://wfto.com/>
4. EFTA. European Fair Trade Association. 2024 [cited 2024 Jul 27]. Efta - FAIR TRADE in EUROPE. Available from: <http://www.european-fair-trade-association.org/efta/index.php>
5. Lyon S, Moberg M. Fair Trade and Social Justice: Global Ethnographies [Internet]. New York, UNITED STATES: New York University Press; 2010 [cited 2020 Jun 1]. Available from: <http://ebookcentral.proquest.com/lib/uwinnipeg/detail.action?docID=865770>
6. Fisher J. In search of dignified work: Gender and the work ethic in the crucible of fair trade production. Am Ethnol [Internet]. 2018 [cited 2019 Aug 27];45(1):74–86. Available from: <https://anthrosource.onlinelibrary.wiley.com/doi/abs/10.1111/amet.12600>
7. Luetchford P. Fair trade and a global commodity: coffee in Costa Rica [Internet]. London: Pluto Press; 2008 [cited 2024 May 22]. (Anthropology, culture, and society). Available from: <http://site.ebrary.com/id/10479940>
8. Sen D. Everyday sustainability: gender justice and fair trade tea in Darjeeling. SUNY Press; 2017.
9. Punsag A, Lonjid Z. Монголчуудын уламжлалт цээрийн өс. Mongol Uls, Shinzhlekh Ukhaany Akademi, Tüükhiiñ Khüreélën; 2003. 160 p.
10. Dolan CS. Fractured Ties: The Business of Development in Kenyan Fair Trade Tea. In: Lyon S, Moberg M, editors. Fair Trade and Social Justice [Internet]. New York University Press; 2020 [cited 2024 May 17]. p. 147–75. Available from: <https://www.degruyter.com/document/doi/10.18574/nyu/9780814796207.003.0007/html>
11. Reinecke J, Ansari S. What Is a “Fair” Price? Ethics as Sensemaking. Organ Sci [Internet]. 2015 Jun [cited 2024 May 17];26(3):867–88. Available from: <https://pubsonline.informs.org/doi/abs/10.1287/orsc.2015.0968>
12. Thrift E. Монголын нүүдлийн соёл ба тогтворой бүтээгдэхүүний стандарт (“тогтвортой ноолуур”-ын жишээн дээр) [Mongolian nomadic culture and sustainable product standards (on the example of “sustainable cashmere”)]. Nomadic Stud. 2023;22(29):335–243.
13. Mongolian Customs Agency. Гадаад худалдааны гүйцэтгэл бараагаар [Foreign trade by commodity] [Internet]. 2024 [cited 2024 May 22]. Available from: <https://gaali.mn/statistic/detail/02>

14. Berger J, Buuveibaatar B, Mishra C. Globalization of the Cashmere Market and the Decline of Large Mammals in Central Asia. *Conserv Biol* [Internet]. 2013 [cited 2019 Oct 16];27(4):679–89. Available from: <https://conbio.onlinelibrary.wiley.com/doi/abs/10.1111/cobi.12100>
15. Dorj O, Enkhbold M, Lkhamyanjin S, Mijiddorj Kh, Nosmoo A, Puntsagnamil M, et al. Mongolia: Country Features, the Main Causes of Desertification and Remediation Efforts. In: Heshmati GA, Squires VR, editors. *Combating Desertification in Asia, Africa and the Middle East: Proven practices* [Internet]. Dordrecht: Springer Netherlands; 2013 [cited 2024 May 22]. p. 217–29. Available from: https://doi.org/10.1007/978-94-007-6652-5_11
16. Davis J. Is cashmere bad for the planet? *Harper's Bazaar* [Internet]. 2020 Jan 24 [cited 2020 Jan 28]; Available from: <https://www.harpersbazaar.com/uk/fashion/fashion-news/a30184355/how-sustainable-is-cashmere/>
17. Dalton M. From H&M to Gucci, Fashion Rethinks Cashmere, Citing Environmental Harm. *Wall Street Journal - Online Edition*. 2019 May 14;1.
18. Ferry T. Pasture degradation threatens Mongolia's cashmere industry. *Nikkei Asian Review* [Internet]. 2017 [cited 2020 Mar 4]; Available from: <https://asia.nikkei.com/Economy/Pasture-degradation-threatens-Mongolia-s-cashmere-industry>
19. Niinimäki K, Peters G, Dahlbo H, Perry P, Rissanen T, Gwilt A. The environmental price of fast fashion. *Nat Rev Earth Environ* [Internet]. 2020 Apr [cited 2023 May 12];1(4):189–200. Available from: <https://www.nature.com/articles/s43017-020-0039-9>.
20. Meier L. Synthesis Report on United Nations System-wide Initiatives related to Fashion [Internet]. UN Alliance for Sustainable Fashion; 2021 [cited 2023 May 12]. Available from: https://unfashionalliance.org/wp-content/uploads/2021/10/UN-Fashion-Alliance-Mapping-Report_Final.pdf
21. Aid by Trade Foundation. The Good Cashmere Standard v2.0 [Internet]. 2024. Available from: <https://thegoodcashmerestandard.org/>
22. Sustainable Fibre Alliance. SFA. 2024 [cited 2024 May 22]. Cashmere Standard. Available from: <https://sustainablefibre.org/resources/>
23. AVSF. Certification: AVSF Sustainable Cashmere [Internet]. 2020 [cited 2022 Aug 10]. Available from: <https://www.sustainablecashmere-mongolia.com/wp-content/uploads/2020/11/Certification-2020-.pdf>
24. International Labour Organization. Convention Concerning Minimum Age for Admission to Employment. Convention 138 Jun 26, 1973.
25. International Labour Organization. Convention Concerning the Prohibition and Immediate Action for the Elimination of the Worst Forms of Child Labour. Convention 182 Jun 17, 1999.
26. Krätli S, Dyer C. Mobile Pastoralists and Education: Strategic Options. IIED; 2009. 76 p.
27. Dyer C. Formal education and pastoralism in western India: inclusion, or adverse

- incorporation? *Comp J Comp Int Educ* [Internet]. 2012 Mar 1 [cited 2024 May 22];42(2):259–81. Available from: <https://doi.org/10.1080/03057925.2011.641359>
28. Yembuu B. Intergenerational learning of traditional knowledge through informal education: the Mongolian context. *Int J Lifelong Educ* [Internet]. 2021 Jul 4 [cited 2024 May 22];40(4):339–58. Available from: <https://doi.org/10.1080/02601370.2021.1967488>
29. Dalziel P, Saunders C, Savage C. Culture, wellbeing, and the Living Standards Framework: A perspective [Internet]. New Zealand Treasury Discussion Paper; 2019 [cited 2024 May 22]. Report No.: 19/02. Available from: <https://www.econstor.eu/handle/10419/205386>
30. Dockery AM. Culture and Wellbeing: The Case of Indigenous Australians. *Soc Indic Res* [Internet]. 2010 Nov 1 [cited 2024 May 22];99(2):315–32. Available from: <https://doi.org/10.1007/s11205-010-9582-y>
31. Gready P. Rights-based approaches to development: what is the value-added? *Dev Pract* [Internet]. 2008 Nov 1 [cited 2024 May 17];18(6):735–47. Available from: <https://doi.org/10.1080/09614520802386454>
32. Cornwall A, Nyamu-Musembi C. Putting the ‘rights-based approach’ to development into perspective. *Third World Q* [Internet]. 2004 Sep 1 [cited 2024 May 17];25(8):1415–37. Available from: <https://doi.org/10.1080/0143659042000308447>
33. International Labour Organization. Indigenous and Tribal Peoples Convention [Internet]. Convention 169 1989. Available from: https://www.un.org/en/genocideprevention/documents/atrocities-crimes/Doc.16_Indigenous%20and%20Tribal%20Peoples%20Convention.pdf
34. UN. United Nations Declaration on the Rights of Indigenous Peoples [Internet]. Resolution 61/295 2007. Available from: https://www.un.org/development/desa/indigenouspeoples/wp-content/uploads/sites/19/2018/11/UNDRIP_E_web.pdf
35. Jacobs A. China Fences In Its Nomads, and an Ancient Life Withers. *The New York Times* [Internet]. 2015 Jul 11 [cited 2023 Jun 12]; Available from: <https://www.nytimes.com/2015/07/12/world/asia/china-fences-in-its-nomads-and-an-ancient-life-withers.html>
36. Fairtrade International. Fairtrade Premium overview [Internet]. 2024 [cited 2024 May 22]. Available from: <https://www.fairtrade.net/impact/fairtrade-premium-overview>
37. Burchard-Dziubińska M, Myagmarjav T. Traditional pastoralism or mining? Conflict of interest in access to natural pastures in Mongolia. *Econ Environ* [Internet]. 2019 Dec 1 [cited 2024 May 22];71(4):13–13. Available from: <https://ekonomiaisrodowisko.pl/journal/article/view/57>
38. Sternberg T. Environmental challenges in Mongolia’s dryland pastoral landscape. *J Arid Environ* [Internet]. 2008 Jul 1 [cited 2024 May 22];72(7):1294–304. Available from: <https://www.sciencedirect.com/science/article/pii/S0140196307003503>
39. Upton C. Contesting development: pastoralism, mining and environmental politics in

- Mongolia. In: Grassroots Environmental Governance. Routledge; 2016.
40. UNESCO World Heritage Committee. Operational Guidelines for the Implementation of the World Heritage Convention [Internet]. 2008. Available from: <https://whc.unesco.org/archive/opguide08-en.pdf>
 41. Pocock C, Lilley I. Who Benefits? World Heritage and Indigenous People. *Herit Soc* [Internet]. 2017 May 4 [cited 2024 May 22];10(2):171–90. Available from: <https://doi.org/10.1080/2159032X.2018.1503836>
 42. Aykan B. 'Patenting' Karagöz: UNESCO, nationalism and multinational intangible heritage. *Int J Herit Stud* [Internet]. 2015 Nov 26 [cited 2024 May 22];21(10):949–61. Available from: <https://doi.org/10.1080/13527258.2015.1041413>
 43. Mongolia, Minister of Education, Culture, Science, and Sport. Монгол Улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл [Representative list of intangible cultural heritage of Mongolia]. Appendix to Resolution A/759 [Internet]. National Centre for Cultural Heritage, Mongolia; 2019 [cited 2024 May 22]. Available from: <http://ncch.gov.mn>
 44. Born of Nomad Cashmere. Born of Nomad — Cashmere from the Mongolian Steppe [Internet]. 2020 [cited 2022 Jun 28]. Available from: <https://www.bornofnomad.com>
 45. Loro Piana. Paid Program: The Secret of Cashmere [Internet]. Loro Piana. 2020 [cited 2022 Jul 6]. Available from: <https://partners.wsj.com/loro-piana/the-secret-of-cashmere/>
 46. Andersson H, Herlitz A. Introduction. In: Andersson H, Herlitz A, editors. *Value Incommensurability: Ethics, Risk, and Decision-Making*. 2021. p. 1–25.
 47. Mair J, Evans NHA. Ethics across borders: Incommensurability and affinity. *HAU J Ethnogr Theory* [Internet]. 2015 Sep [cited 2024 May 22];5(2):201–25. Available from: <https://www.journals.uchicago.edu/doi/full/10.14318/hau5.2.013>
 48. Waz M. Breaking PETA Exposé Reveals Cruelty in Your Cashmere Sweater [Internet]. PETA Exposés and Undercover Investigations. 2019 [cited 2022 Jul 12]. Available from: <https://investigations.peta.org/cashmere-cruelty-china-mongolia/>
 49. Stella McCartney. Stella McCartney. 2022 [cited 2022 Jul 22]. Recycled cashmere | Stella McCartney US. Available from: <https://www.stellamccartney.com/us/en/sustainability/recycled-cashmere.html>
 50. Government of Mongolia. НООЛУУРЫН САЛБАРТ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ [Some actions to be implemented in the cashmere sector] [Internet]. Mar 19, 2020. Available from: <https://legalinfo.mn/>
 51. Hashempour P. Can regenerative wool make fashion more sustainable? BBC News [Internet]. 2023 Apr 13 [cited 2024 May 22]; Available from: <https://www.bbc.com/future/article/20230413-can-regenerative-wool-make-fashion-more-sustainable>
 52. Fibershed. Climate Beneficial™ Wool [Internet]. 2024 [cited 2024 May 22]. Available from: <https://fibershed.org/climate-beneficial-wool/>